



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/172

Булган

### Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх” төсөл арга хэмжээний хүрээнд автомашин худалдан авах ажлыг 40 000 000 /дөчин сая/ төгрөгөөр “Агро эрдэнэ” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Жаргалсайхан/-д олгосугай.

2. Техникийн тодорхойлолтод заагдсан нөхцөл, шаардлага, тоо хэмжээний дагуу хууль журмын хүрээнд гэрээ байгуулж, чанар, хугацаанд хяналт тавьж, барааг хүлээн авахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ



D:\ЗДТГ,ХОХБТХ\Захирамж

20190173